

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалт /зүйл, хэсэг, заалт/-д тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зохицуулалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль нь 2010 оны 7 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан бөгөөд нийт 44 зүйлтэй. Өнөөдрийн байдлаар нийт 6 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр нийт хуулийн зохицуулалтын 50-аас дээш хувьд өөрчлөлт орсон байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн зорилтод гадаадын иргэний эрх зүйн байдлыг тогтоож, гадаадын иргэн Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суухтай холбогдсон харилцааг зохицуулахыг зорьсон гэжээ.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба төрийн тусгай албанд хамаарах эсэх асуудлаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангаас харахад энэхүү хуулийн төслөөр дараах гол асуудлыг шийдвэрлэхийг зорьсон байна:

- Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг төрийн тусгай алба болохыг холбогдох хуульд тусгах,

- төрийн тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд тус байгууллагын албан хаагчийг төрийн тусгай албан тушаалд хамруулах, эрх зүйн байдал, нийгэм, эдийн засгийн баталгааг сайжруулах.

Үүнтэй холбогдуулан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулжээ.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль, “Хуулийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлал”¹ /цаашид “Аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ:

¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

- 1.1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 1.2.Хуулийн төслөөс үр нөлөө үнэлэх хэсгээ тогтоох;
- 1.3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 1.4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалд дурдсан нийт 6 шалгуур үзүүлэлтээс дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 2.1.Зорилгод хүрэх байдал
- 2.2.Зардал
- 2.2.Харилцан уялдаа.

Дээрх шалгуур үзүүлэлтийг тухайлан сонгох болсон үндэслэл нь хуулийн төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, үндсэн зорилго, зохицуулах харилцааны онцлогт нийцүүлэх, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад энэхүү судалгааны ажлын гол зорилго оршино.

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба төрийн тусгай албанд хамаарах эсэх асуудлаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайланд “Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагыг төрийн тусгай албанд, түүний албан хаагчийг төрийн тусгай албан тушаалд хамруулах, төрийн тусгай албан тушаалд нийцэх эрх зүйн байдал, баталгаагаар хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоогоор хангах” зорилгын хүрээнд хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэнтэй холбогдуулан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсныг хуулийн төслийн үзэл баримтлалд дурджээ.

Иймд хуулийн төслийн үзэл баримтлалаар дэвшүүлсэн зорилтын хүрээнд хуулийн төсөлд өөрчлөхөөр болон шинээр тусгахаар заасан зохицуулалт нь үзэл баримтлалын зорилтыг хангасан эсэхийг тогтоох, ялангуяа хуулийн төслийн зохицуулалтаар гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллага төрийн тусгай албанд, тус байгууллагын албан хаагч төрийн тусгай албан тушаалд хамаарах эсэх, үүнтэй холбогдуулан эрх зүйн байдал, баталгааг чиг үүргээ хэрэгжүүлэх, бие даасан байдлаар ажиллах нөхцөл бүрдэх эсэхийг тогтоох, энэхүү зорилгод нийцүүлэн тусгасан зохицуулалтын улмаас иргэн, хуулийн этгээд, улсын төсөвт ачаалал үүсэх эсэх, эдгээр зохицуулалт харилцан уялдаа бүхий бусад хуультай уялдсан эсэхэд дүн шинжилгээ хийх зорилгоор дээр дурдсан 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллага төрийн тусгай албанд, тус байгууллагын албан хаагч төрийн тусгай албан тушаалд хамруулах, албан хаагчдын эрх зүйн байдал, баталгааг чиг үүргээ хэрэгжүүлэх, бие даасан байдлаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх гэсэн үндсэн зорилгод нийцсэн эсэх асуудлыг судалж, боломжит хувилбарыг тодорхойлохыг зорьсон.

“Зардлын тооцоо” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд туссан “41.24.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн болон хуульд заасан бусад нэмэгдлээс тус тус бүрдэнэ.”, “41.27.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг ажилласан 1 жил тутамд 1 жил 3 сар ажилласанд тооцно.”, “41.28.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол 36 хүртэл сарын цалинтай тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламжийг сарын дундаж цалин хөлснөөс тооцох ба тэтгэврийг тэтгэвэр тогтоолгогчийн сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно.” гэх зохицуулалт нь иргэн, хуулийн этгээд, улсын төсөвт ачаалал үүсгэх эсэх, зардал үр өгөөжийн харьцааг тодруулахаар сонгов.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь сонгож, зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуульд нийцсэн эсэх, бусад байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах замаар шалгахаар сонгов.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН-БАЙДАЛ

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон тул түүнд хамаарах үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоохдоо хуулийн төслийн үзэл баримтлалд үндэслэн хуулийн төслийн зохицуулалт бүхэлдээ чухал, ач холбогдолтойг харгалзан хуулийн төслийг бүхэлд нь, харин зардал үүсгэх магадлал бүхий зарим хэсгийг зардлыг тооцох шалгуур үзүүлэлтийн хүрээнд нь сонголоо:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг
3.1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ
3.2	Зардлын тооцоо	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл буюу хуулийн 41.24, 41.27, 41.28 дахь хэсэг
3.3	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт, үр нөлөөг үнэлэх хэсгийг тус тус тогтоож, тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар тодорхойллоо:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
4.1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Зорилгод дүн шинжилгээ хийх: Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан зорилгод нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
4.2.	Зардал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл буюу хуулийн 41.24, 41.27, 41.28 дахь хэсэг	Зардлын тооцоо хийх Хуулийн төслийн зохицуулалт иргэн, хуулийн этгээд, улсын төсөвт ачаалал үүсгэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
4.3.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах: Хуулийн төслийн уялдаа холбоог Аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар шалгана.

4.1 Шалгуур үзүүлэлт: Зорилгод хүрэх байдал

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь сонгосон бөгөөд бодит байдал дээр хуулийн төслийн үзэл баримтлалд заасан зорилгод хүрэх боломжтой эсэхийг албан ёсны мэдээлэл, холбогдох баримтад тулгуурлан судалсан.

Хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төслөөр зохицуулах асуудлыг дараах байдлаар тусгажээ:

- Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагыг төрийн тусгай албанд, түүний албан хаагчийг төрийн тусгай албан тушаалд хамруулах,
- төрийн тусгай албан тушаалд нийцэх эрх зүйн байдал, баталгаагаар хангах.

Иймд дээрх асуудлыг шийдвэрлэхэд анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлагатай ба энэ зорилтыг хангахын тулд холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд дараах байдлаар тусгасан байна:

Хүснэгт 1

Хуулийн төслөөс:

“1 дүгээр зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/41 дүгээр зүйлийн 41.13, 41.14, 41.15, 41.16, 41.17, 41.18, 41.19, 41.20, 41.21, 41.22, 41.23, 41.24, 41.25, 41.26, 41.27, 41.28 дахь хэсэг:

41.13.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн албан тушаал нь дараах ангилалтай байна:

- 41.13.1.Тэргүүн түшмэл;
- 41.13.2.Шадар түшмэл;
- 41.13.3.Эрхэлсэн түшмэл;
- 41.13.4.Ахлах түшмэл;
- 41.13.5.Дэс түшмэл;
- 41.13.6.Туслах түшмэл.

43.14.Тэргүүн түшмэлийн албан тушаалд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын удирдах төв байгууллагын дарга хамаарна.

43.15.Шадар түшмэлийн албан тушаалд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын удирдах төв байгууллагын дэд дарга хамаарна.

43.16.Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтцийн нэгжийн дарга хамаарна.

43.17.Ахлах түшмэлийн албан тушаалд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналтын улсын ахлах байцаагч, ахлах мэргэжилтэн хамаарна.

43.18.Туслах түшмэлийн албан тушаалд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн хамаарна

43.19.Тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаал нь тус бүртээ тэргүүн зэрэг, дэд зэрэг, гутгаар зэрэг, дөтгөөр зэрэг гэсэн зэрэг дэвтэй байна.

43.20.Энэ хуулийн 43.19-д заасан зэрэг дэвийг дараахь албан тушаалтан олгоно:

43.20.1.тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхийлөгч;

43.20.2.эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг

Монгол Улсын Ерөнхий сайд;

43.20.3.ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга.

43.21.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг Засгийн газар батална.

43.22.Эрхэлж байгаа албан тушаалаас нь хамаарч гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төрийн тусгай албан хаагчид дараах цол олгоно:

- 41.22.1.ерөнхий байцаагч;
- 41.22.2.шадар байцаагч;
- 41.22.3.эрхэлсэн байцаагч;
- 41.22.4.ахлах байцаагч;
- 41.22.5.байцаагч;
- 41.22.6.дэд байцаагч.

41.23.Энэ хуулийн 43.13-т заасан цолны албан тушаалын ангилал, зэрэглэл, цолны нэмэгдэл олгох журмыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга тогтооно.

41.24.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын үндсэн цалин, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн болон хуульд заасан бусад нэмэгдлээс бүрдэнэ.

41.25.Энэ хуулийн 41.24-д заасан албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

41.26.Хуульд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нь зэрэг дэвийн болон цолны нэмэгдлийн аль нэгийг сонгох эрхтэй.

41.27.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг ажилласан 1 жил тутамд 1 жил 3 сар ажилласанд тооцно.

41.28.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол 36 хүртэл сарын цалинтай тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламжийг сарын дундаж цалин хөлснөөс тооцох ба тэтгэврийг тэтгэвэр

тогтоолгогчийн сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно.

41.28.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн ээлжийн амралтын хоногийг тооцохдоо ажилласан 5 жил тутамд 1 хоногийн нэмэгдэл амралт олгоно.”

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 39-41 дүгээр зүйлд төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэх бүрэн эрх, ажилтны эрх зүйн байдал, баталгааг дараах байдлаар тусгажээ:

Хүснэгт 2

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиас:

**НАЙМДУГААР БҮЛЭГ
ГАДААДЫН ИРГЭНИЙ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГА, АЖИЛТНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, БАТАЛГАА**

39 дүгээр зүйл.Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо

39.1.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь удирдах төв байгууллага, түүний хилийн боомт, орон нутаг дахь албадаас бүрдэнэ.

**40 дүгээр зүйл.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн
захиргааны байгууллагын бүрэн эрх**

40.1.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

40.1.1.гадаадын иргэний талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

40.1.2.гадаадын иргэний талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

40.1.3.гадаадын иргэний асуудлаар Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

40.1.4.гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн цаасан болон цахим мэдээллээс бүрдсэн нэгдсэн санг хөтлөх, сангийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангах, сангаар дамжуулан төрийн холбогдох байгууллагатай харилцан мэдээлэл солилцох;

40.1.5.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

40.1.6.Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх шийдвэр гаргах;

40.1.7.Монгол Улсад цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэний гарах-орох мэдэгдлийг бүртгэх. Энэ мэдэгдлийг гадаадын иргэн Монгол Улсын хилээр гарах орохоосоо 72 цагаас доошгүй хугацааны өмнө гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

40.1.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

40.2.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 27.3-т заасны дагуу татгалзсан хариу өгсөн тохиолдолд шалтгааныг нь тайлбарлах үүрэг хүлээхгүй.

40¹ дүгээр зүйл.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан

40¹.1.Монгол Улс нь гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байна. Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь төрийн өмч байх бөгөөд улсын хилээр нэвтрэх зорчигчийн бүртгэлийн нэгдсэн сантай холбогдоно.

40¹.2.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь Монгол Улсын виз мэдүүлсэн, виз олгосон, виз олгохоос татгалзсан, Монгол Улсын хилээр нэвтэрсэн, Монгол Улсад түр ирэгч, албан хэргээр болон хувийн хэргээр оршин суусан, Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн, албадан гаргасан, албадан гаргахаас чөлөөлөгдсөн, Монгол Улсад тааламжгүй этгээдээр зарлагдсан зэрэг гадаадын иргэний талаарх цаасан болон цахим мэдээллийн сангаас бүрдэнэ.

40¹.3.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн нууцлалыг хангах үүргийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээнэ.

40¹.4.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг цахим хэлбэрээр бүрдүүлэх, хөгжүүлэх болон төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох, эрх бүхий байгууллага хамтран ашиглах боломжтой байна.

40¹.5.Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах, мэдээлэл нийлүүлэх, солилцох журмыг хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

41 дүгээр зүйл.Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, түүний бүрэн эрх, баталгаа

41.1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх эрх олгогдсон Монгол Улсын иргэнийг гадаадын иргэний хяналтын улсын байцаагч гэнэ.

41.2.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын ерөнхий байцаагч байна.

41.3.Гадаадын иргэний хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч (цаашид "байцаагч" гэх)-ийн эрх олгох, уг эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг гадаадын иргэний хяналтын улсын ерөнхий байцаагч шийдвэрлэнэ.

41.4.Улсын байцаагч нь "Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч би, Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангахын төлөө үнэнчээр зүтгэж, гадаадын иргэн болон түүний баримт бичигт хяналт, шалгалт хийхдээ хүний эрх, хууль, шударга ёсыг дээдлэн, улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, хэний ч нөлөөнд үл автахаа батлан тангараглая. Өргөсөн тангаргаас няцвал төрийн хуулийн цээрлэл хүлээнэ" гэсэн тангараг өргөнө.

41.5.Улсын байцаагч нь дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх ба дүрэмт хувцас, ялгах тэмдгийн загвар, хэрэглэх журам, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

41.6.Улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэгтэй ижил загварын дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэхийг бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хориглоно.

41.7.Улсын байцаагч Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

41.7.2.гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичигт үзлэг шалгалт хийж, зөрчлийг шийдвэрлэх хүртэл хадгалах, эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

41.7.3.гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх тухай дүгнэлт гаргах;

41.7.4.гадаадын иргэнийг Монгол Улсаас гаргахыг түдгэлзүүлсэн, албадан гаргасан шийдвэрийг цуцлах санал гаргах;

41.7.6.хууль тогтоомжид заасан бусад.

41.8.Улсын байцаагчийн хилийн боомтод ажилласан нэг жилийг нэг жил гурав сар ажилласанд тооцох ба хилийн боомт, орон нутаг дахь албанд таваас

доошгүй жил ажиллаж байгаа ажилтанд ажилласан таван жил тутам 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоно.

41.9.Улсын байцаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ дараах тусгай хэрэгсэл, мэх ашиглаж болно:

- 41.9.1.нэг бүрийн тусгай хэрэгсэл;
- 41.9.2.тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл;
- 41.9.3.хамгаалах тусгай хэрэгсэл;
- 41.9.4.бие хамгаалах урлагийн зэвсэггүйгээр тулалдах мэх.

41.10.Энэ хуулийн 41.9-д заасан тусгай хэрэгсэл, мэхийг дараах тохиолдолд ашиглаж болно:

41.10.1.улсын байцаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй, эсхүл хүч хэрэглэж эсэргүүцсэн;

41.10.2.хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон.

41.11.Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэснээс хүний амь бие, эрүүл мэндэд гэмтэл учирсан тохиолдолд улсын байцаагч эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ авч, энэ тухай харьяа байгууллагын даргад мэдэгдэнэ.

41.12.Тусгай хэрэгслийн жагсаалт, хэрэглэх, хадгалах зааврыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батална.

Дээр дурдсан зохицуулалтаас харахад Гадаадын иргэний асуудал эрхэлсэн байгууллага нь төрийн захиргааны байгууллага байхаар, удирдах төв байгууллага, түүний хилийн боомт, орон нутаг дахь албадаас бүрдэхээр заажээ. Тус байгууллага нь хуульд заасны дагуу “гадаадын иргэний талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; гадаадын иргэний талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; гадаадын иргэний асуудлаар Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн цаасан болон цахим мэдээллээс бүрдсэн нэгдсэн санг хөтлөх, сангийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангах, сангаар дамжуулан төрийн холбогдох байгууллагатай харилцан мэдээлэл солилцох; олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих; Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх шийдвэр гаргах; Монгол Улсад цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэний гарах-орох мэдэгдлийг бүртгэх. Энэ мэдэгдлийг гадаадын иргэн Монгол Улсын хилээр гарах орохоосоо 72 цагаас доошгүй хугацааны

өмнө гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх; хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх"-ийг хэрэгжүүлэхээр байна.

Тус байгууллагад Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч ажиллах бөгөөд улсын байцаагч нь дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх, гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичигт үзлэг шалгалт хийж, зөрчлийг шийдвэрлэх хүртэл хадгалах, эрх бүхий байгууллагад шилжүүлэх; гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх тухай дүгнэлт гаргах; гадаадын иргэнийг Монгол Улсаас гаргахыг түдгэлзүүлсэн, албадан гаргасан шийдвэрийг цуцлах санал гаргах; албан үүргээ гүйцэтгэх үедээ дараах тусгай хэрэгсэл, мэх ашиглах, хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдлэхээр заасан байна.

Нийгэм, эдийн засгийн баталгааны хувьд “Улсын байцаагчийн хилийн боомтод ажилласан нэг жилийг нэг жил гурав сар ажилласанд тооцох ба хилийн боомт, орон нутаг дахь албанд таваас доошгүй жил ажиллаж байгаа ажилтанд ажилласан таван жил тутам 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал” авахаар байна.

Харин хуулийн төсөлд шинээр Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн албан тушаалыг Тэргүүн түшмэл; Шадар түшмэл; Эрхэлсэн түшмэл; Ахлах түшмэл; Дэс түшмэл; Туслах түшмэл гэсэн ангилалтай байхаар, үүнтэй нийцүүлсэн зэрэглэл, зэрэг дэвтэй байхаар заасан нь Төрийн албаны тухай хуулийн 18-21 дүгээр зүйлд заасан төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв зэрэгтэй давхцаж байгаа нь төрийн захиргааны албан тушаал уу, төрийн тусгай албан тушаал уу гэдгийг тодорхой болгоогүй ойлгомжгүй байдал үүсгэхээр байна. Мөн Төрийн албаны тухай хуулийн зохицуулалтыг давхардуулан тусгасан гэж харагдахаар байгааг анхаарах шаардлагатай байна. Харин хуулийн төсөлд албан хаагчийн нийгэм, эдийн засгийн баталгааг төрийн тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийнхтай нийцүүлсэн нь эрх зүйн байдлыг дээрдүүлсэн зохицуулалт болсон байна.

Мөн хуулийн төсөлд “41.28.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол 36 хүртэл сарын цалинтай тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламжийг сарын дундаж цалин хөлснөөс тооцох ба тэтгэврийг тэтгэвэр тогтоолгогчийн сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно.” гэж заасан нь Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт “Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.” гэж заасантай зөрчилдөж байгааг анхаарах шаардлагатай байна.

Харин хуулийн төсөлд “41.27.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг ажилласан 1 жил тутамд 1 жил 3 сар ажилласанд тооцно.”, “41.28.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн ээлжийн амралтын хоногийг тооцохдоо ажилласан 5 жил тутамд 1 хоногийн нэмэгдэл амралт олгоно.” гэж заасан нь бусад хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагын нэгэн адил албан хаагчийн эрх зүйн байдал, эдийн засгийн баталгааг хангасан шинжтэй хуулийн зохицуулалт болсон байна.

Харин хуулийн төслийн зорилтын хүрээнд Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Төрийн албаны тухай хуульд заасан тусгай алба болох, албан хаагчид нь төрийн тусгай албан тушаалд хамаарах талаар тодорхой заагаагүй байгаа тул энэ талаар тусгах шаардлагатай.

4.2.Шалгуур үзүүлэлт: Зардлын тооцоо

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлгээний “Зардлын тооцоо” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээний тайланг энэхүү тайланд хавсралтаар хавсаргав.

4.3.Шалгуур үзүүлэлт: Хуулийн төслийн уялдаа холбоо

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах, хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоох зорилгоор Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-т заасан заасан шалгуурт нийцүүлэн боловсруулсан асуултад хариулах байдлаар шалгаж үнэллээ.

Хүснэгт 3

Д/д	Асуултууд	Хариулт
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Тийм
4	Хуулийн төслийн хэсэг, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хууль тогтоомжийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм
5	Хуулийн төслийн хэсэг, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжийн заалттай давхардсан эсэх;	Тийм. Хуулийн төслийн зарим зохицуулалт Төрийн албаны тухай хуулийн

		зохицуулалттай давхардсан, зөрчилдсөн шинжтэй байгааг нийцүүлэх шаардлагатай.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Тийм. Төрийн албаны тухай хуульд заасан аль алба, албан тушаалд хамаарах асуудлыг тодорхой заагаагүй байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй. Гэвч Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагын харьяатын асуудлыг Харьяатын тухай хуулиар зохицуулсан байгааг анхаарч уялдуулах шаардлагатай.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй
13	Хуулийн төслийн хэсэг, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй

16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлд хориглосон хэм хэмжээ байхгүй байна.
----	--	---

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Аргачлалын 4.10-г заасан шалгуурт нийцүүлэн боловсруулсан асуултад хариулах байдлаар хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн бөгөөд хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байна. Харин хуулийн төслийн зарим зохицуулалт Төрийн албаны тухай хуулийн зохицуулалттай давхардсан байх ба Төрийн албаны тухай хуульд заасан аль алба, албан тушаалд хамаарах асуудлыг тодорхой заагаагүй байгааг анхаарах шаардлагатай байна. Мөн Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагын эрхлэх асуудалд хамаарах харьяатын асуудлыг Харьяатын тухай хуулиар зохицуулсан байгааг анхаарч уялдуулах асуудлыг нягтлах шаардлагатай.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шатыг Аргачлалын 5-д заасны дагуу дараах дарааллаар хийлээ:

- 5.1.үр дүнг баримтжуулах;
- 5.2.үнэлэх;
- 5.3.зөвлөмж өгөх.

5.1.Үр дүнг баримтжуулах: Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг холбогдох шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн бөгөөд холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн акт болон хамаарал бүхий холбогдох мэдээлэл, тоо баримт зэрэг бусад материалыг ашиглаж, ашигласан материалын жагсаалтыг үнэлгээний тайланд хавсаргаснаас гадна үнэлгээ хийсэн хуулийн төслийг хавсаргасан болно.

Хуулийн төсөл нь үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, зардал үүсгэх эсэх, бусад хуультай хэрхэн уялдсан гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийж, зөвлөмж боловсрууллаа.

5.2.Дүгнэлт: Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн ба шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэвэл:

Зорилгод хүрэх байдал: Хуулийн төслөөр Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба төрийн тусгай албанд хамаарах эсэх асуудлаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайланд “Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагыг төрийн тусгай албанд, түүний албан хаагчийг төрийн тусгай албан тушаалд хамруулах, төрийн

тусгай албан тушаалд нийцэх эрх зүйн байдал, баталгаагаар хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл бололцоогоор хангах” асуудлыг шийдвэрлэхийг зорьсон талаар хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан. Харин хуулийн төсөлд шинээр Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн албан тушаалын ангилал, үүнд нийцүүлсэн зэрэглэл, зэрэг дэвийг зохицуулсан ба энэ нь Төрийн албаны тухай хуулийн 18-21 дүгээр зүйлийн зохицуулалттай давхардсан байгаагаас гадна Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Төрийн албаны тухай хуульд заасан тусгай алба болох, албан хаагчид нь төрийн тусгай албан тушаалд хамаарах талаар тодорхой заагаагүй байгаа тул энэ талаар тусгах шаардлагатай байна. Харин хуулийн төсөлд албан хаагчийн нийгэм, эдийн засгийн баталгааг төрийн тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийнхтай нийцүүлсэн нь эрх зүйн байдлыг дээрдүүлсэн зохицуулалт болсон байна. Мөн хуулийн төсөлд “41.28.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол 36 хүртэл сарын цалинтай тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламжийг сарын дундаж цалин хөлснөөс тооцох ба тэтгэврийг тэтгэвэр тогтоолгогчийн сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно.” гэж заасан нь Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт “Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.” гэж заасантай зөрчилдөж байгааг анхаарах шаардлагатай байна.

Зардал: Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээний “Зардлын тооцоо” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээний тайланг энэхүү тайланд хавсралтаар хавсаргав.

Харилцан уялдааг хангасан байдал: Хуулийн төслийг харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд бүхэлд нь Аргачлалд заасан асуултад хариулах байдлаар хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн бөгөөд хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй боловч хуулийн төслийн зарим зохицуулалт Төрийн албаны тухай хуулийн зохицуулалттай давхардсан байгааг анхаарах шаардлагатай байна.

5.3.Зөвлөмж:

Энэхүү хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын явцад гарсан дараах асуудлыг анхаарч, хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах чиглэлээр өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна:

- ✓ Хуулийн төсөлд шинээр гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн албан тушаалын ангилал, үүнд нийцүүлсэн

зэрэглэл, зэрэг дэвийг зохицуулсан ба энэ нь Төрийн албаны тухай хуулийн 18-21 дүгээр зүйлийн зохицуулалттай давхардсан байгаа тул давхардлыг арилгах;

- ✓ Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Төрийн албаны тухай хуульд заасан тусгай алба болох, албан хаагчид нь төрийн тусгай албан тушаалд хамаарах талаар тодорхой заагаагүй байгаа тул үүнийг тодорхой тусгах;
- ✓ Хуулийн төсөлд “41.28.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол 36 хүртэл сарын цалинтай тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламжийг сарын дундаж цалин хөлснөөс тооцох ба тэтгэврийг тэтгэвэр тогтоолгогчийн сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно.” гэж заасан нь Төрийн албаны тухай хуулийн 60.1-д “Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.” гэж заасантай зөрчилдөж байх тул нийцүүлэх;
- ✓ Хуулийн төслийн зарим зохицуулалт Төрийн албаны тухай хуулийн зохицуулалттай давхардсан байгаа тул давхардлыг нягтлан арилгах.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай 41 дүгээр зүйлийн 41.13 -41.29 дэх хэсэг нэмсүгэй:

“41.13.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн албан тушаал нь дараах ангилалтай байна:

- 41.13.1.Тэргүүн түшмэл;
- 41.13.2.Шадар түшмэл;
- 41.13.3.Эрхэлсэн түшмэл;
- 41.13.4.Ахлах түшмэл;
- 41.13.5.Дэс түшмэл;
- 41.13.6.Туслах түшмэл

41.14.Тэргүүн түшмэлийн албан тушаалд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын удирдах төв байгууллагын дарга хамаарна.

41.15.Шадар түшмэлийн албан тушаалд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын удирдах төв байгууллагын дэд дарга хамаарна.

41.16.Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтцийн нэгжийн дарга хамаарна.

41.17.Ахлах түшмэлийн албан тушаалд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналтын улсын ахлах байцаагч, ахлах мэргэжилтэн хамаарна.

41.18.Туслах түшмэлийн албан тушаалд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн хамаарна

41.19.Тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаал нь тус бүртээ тэргүүн зэрэг, дэд зэрэг, гутгаар зэрэг, дөтгөөр зэрэг гэсэн зэрэг дэвтэй байна.

41.20.Энэ хуулийн 41.19-д заасан зэрэг дэвийг дараахь албан тушаалтан олгоно:

41.20.1.тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхийлөгч;

41.20.2.эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхий сайд;

41.20.3.ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга.

41.21.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг Засгийн газар батална.

41.22.Эрхэлж байгаа албан тушаалаас нь хамаарч гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төрийн тусгай албан хаагчид дараах цол олгоно:

- 41.22.1.ерөнхий байцаагч;
- 41.22.2.шадар байцаагч;
- 41.22.3.эрхэлсэн байцаагч;
- 41.22.4.ахлах байцаагч;
- 41.22.5.байцаагч;
- 41.22.6.дэд байцаагч.

41.23.Энэ хуулийн 41.22-т заасан цолны албан тушаалын ангилал, зэрэглэл, цолны нэмэгдэл олгох журмыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга тогтооно.

41.24.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн болон хуульд заасан бусад нэмэгдлээс тус тус бүрдэнэ.

41.25.Энэ хуулийн 41.24-д заасан албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

41.26.Хуульд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нь зэрэг дэвийн болон цолны нэмэгдлийн аль нэгийг сонгох эрхтэй.

41.27.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг ажилласан 1 жил тутамд 1 жил 3 сар ажилласанд тооцно.

41.28.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол 36 хүртэл сарын цалинтай тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламжийг сарын дундаж цалин хөлснөөс тооцох ба тэтгэврийг тэтгэвэр тогтоолгогчийн сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно.

41.29.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн ээлжийн амралтын хоногийг тооцохдоо ажилласан 5 жил тутамд 1 хоногийн нэмэгдэл амралт олгоно.”

41.30.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийг хуульд зааснаас бусад тохиолдолд ажлаас чөлөөлөх, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

I.Хууль тогтоомж, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын хууль
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
- Харьяатын тухай хууль
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Цагдаагийн албаны тухай хууль
- Гаалийн тухай хууль

II.Засгийн газрын тогтоол

- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

III.Ном, гарын авлага, эмхэтгэл, судалгааны материал

- Төрийн албан хаагчдын аж байдал, нийгмийн баталгааны өнөөгийн байдал, 2002
- Гадаадын иргэн, харьяатын газрын түүхэн товчоо, 2020
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд хийх хавсарга судалгаа, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2008
- Иргэний харьяалал ба шилжих хөдөлгөөн, Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл 2013
- Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/, Улаанбаатар хот, 2016 он;

IV. Интернэт эх сурвалж

- www.legalinfo.mn
- <https://immigration.gov.mn/mn/historylist/>
- <https://nli.gov.mn/gariinavlaga/Irgenii%20Kharyalal.pdf>
- <https://academy.edu.mn/content/57495826-2/>
- <https://nli.gov.mn/pdf/gadaadiin irgeiin erh zuin baidliin.pdf>
- <https://www.state.gov/>

- <https://www.dhs.gov/>
- <https://www.uscis.gov/>
- <https://www.ice.gov/>